

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 31

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,251.2 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27,230.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 9,046.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 10,257.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 хөтөлбөр, 7 зорилт, 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 38 арга хэмжээг бүрэн, 3 арга хэмжээг 90.0 хувь, 1 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 97.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702900310

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Мян.Төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,047.90	42,500.60
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	298,009.90	269,808.38
	Нийт хөрөнгийн дүн	300,057.80	312,308.98
	Нийт өр төлбөрийн дүн	1,637.23	4,325.57
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	298,420.57	307,983.42
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	300,057.80	312,308.98
	Үйл ажиллагааны орлогын дүн	395,947.25	303,819.15
	Үйл ажиллагааны зардлын дүн	202,717.37	294,256.31
	Үйл ажиллагааны үр дүн	193,229.87	9,562.84
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	193,229.87	9,562.84
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		298.42	307.98
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	105,190.70	298,420.57
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
	Тайлант оны үр дүн	193,229.87	9,562.84
	Эцсийн үлдэгдэл	298,420.57	307,983.42
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	163,069.64	-
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	163,069.64	-
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	143,254.65	197,489.80
	Урсгал зардал	143,254.65	197,489.80
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,327,555.80	2,005,113.30
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,254.65	197,489.80

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 7,595.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 315.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, бараа материалаас 5,000.0 мянган төгрөгийн самбарыг биетээр байхад шууд зарлагдсан, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,280.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд орлого авч шууд зарлагад бичсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"

Аудитаар нийт 4,362.1 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 4,041.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 321.1 мянган төгрөгийн төлбөрийн акт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулж 321.1 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулж олгосон цалинг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалийн шимтгэлд 4,041.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн алба	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 315.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	315.0	-	-	1	315.0	1	315.0	-	-	-	-
	Бараа материалаас 5,000.0 мянган төгрөгийн самбарыг биетээр байхад шууд зарлагадсан	1	5,000.0	-	-	1	5,000.0	1	5,000.0	-	-	-	-
	Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,280.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд орлого авч шууд зарлагад бичсэн	1	2,280.0	-	-	1	2,280.0	1	2,280.0	-	-	-	-
Дүн		3	7,595.0	-	-	-	7,595.0	3	7,595.0	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/											
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн								
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дэлгэр сумын Гуулин тосгоны	Амралтын цалинг үндсэн цалинтай давхаруулж 321.1 мянган төгрөгийг олгосон	1	321.1	1	321.1	-	-	-	-	-	-

Захирагчийн алба	Цалингийн зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалийн шимтгэлд 4,041.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	4,041.0	-	-	1	4,041.0	-	-	-	-
Нийт		2	4,362.1	1	321.1	1	4,041.0	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн алба	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26,542,4 мянган төгрөгийн 3 , цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,000.0 мянган төгрөгийн 1, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээллээгүй	1	-					1	-		
Нийт		1	-	-	-	-	-	1	-	-	-